Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын
2024 оны .......... сарын ....-ны өдрийн
.................................... дугаартай
албан бичгийн хавсралт

# НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
# “АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр | Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулах хөрөнгө мян/төг | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | 1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх | Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) | Жилдээ | Тухай бүрт | - | -Нийслэлийн Аялал жуулчлалын газрын “Авлигын эсрэг үйл ажиллагаа”-ны 2024 оны төлөвлөгөөг 2024 оны 03-р сарын 18-ны өдөр газрын даргаар батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. АТГ-аас гаргасан нийтлэл, зурагт хуудсыг байгууллагын албан ёсны цахим хуудас, сурталчилгааны самбарт байршуулан олон нийтэд ил тод мэдээлэн ажилласан. Нийт 2 төрлийн мэдээллийг байгууллагын facedook цахим хуудсанд байршуулж, нийт 636 хүнд хүргэж, 36 шэйр хийсэн.<br>-АТГ-аас гаргасан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай нийт 12 төрлийн танилцуулга, баннер, зурагт хуудсыг нийт албан хаагчдад танилцуулж мэдээлэл хүргүүлсэн. Мөн плакат, брошюур, наалтыг газрын мэдээллийн салбар, хаалга, өрөө тасалгаанд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байршуулж, Сүхбаатарын талбай, Төв шуудан, Хөшгийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудалд үйл ажиллагаа явуулдаг жуулчдын Мэдээллийн төвүүдээр дамжуулан иргэдэд тараасан. | |
| | | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах | 2-оос доошгүй нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байх | Жилдээ | Тухай бүрт | - | Аялал жуулчлалын салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг сошиал, цахимаар дамжуулан хийлээ. “АВЛИГААС ТАТГАЛЗАХ БОЛОМЖ БИДЭНД БИЙ”, “АВЛИГАД ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЦГЭЭЕ” гэсэн уриалга дэвшүүлж, авлигын эсрэг үйлдлийг “110 УТАС РУУ ҮНЭГҮЙ ЗАЛГАХ БОЛОМЖТОЙ” гэсэн 2 төрлийн баннерыг нийслэлийн Аялал жуулчлалын газраас хөтлөн явуулдаг амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудал зэрэг аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын нийт 33,300 иргэний бүртгэлтэй 3 төрлийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэсэн. | 100% |
| | | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах | Мэдээллийг сар бүр шинэчлэх | Жилдээ | Тухай бүрт | - | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн буланг сар бүр тогтмол шинэчлэн ажиллаж байна. | 100% |
| | | 1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошюр зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд | -2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх,<br>-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, | Жилдээ | Тухай бүрт | - | -Нийт 4 төрлийн мэдээллийг байгууллагын facedook цахим хуудсанд байршуулж, нийт 1356 хүнд хүргэж, 82 шэйр хийсэн байна. Үүнээс гадна аялал жуулчлалын салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг сошиал, цахимаар дамжуулан хийлээ. “АВЛИГААС ТАТГАЛЗАХ БОЛОМЖ БИДЭНД БИЙ”, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүргэх | инстаграм, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх<br>-Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх. | | | | "АВЛИГАД ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЦГЭЭЕ" гэсэн уриалга дэвшүүлж, авлигын эсрэг үйлдлийг "110 УТАС РУУ ҮНЭГҮЙ ЗАЛГАХ БОЛОМЖТОЙ" гэсэн 2 төрлийн баннерыг нь нийслэлийн Аялал жуулчлалын газраас хөтлөн явуулдаг амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудал зэрэг аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын нийт 33,300 иргэний бүртгэлтэй 3 төрлийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэсэн. | |
| 2. | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | 2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах | Шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх | Жилдээ | Тухай бүрт | - | -Албан хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэг чадварыг хөгжүүлэх, сайжруулах зорилгоор ёс зүйн чиглэл, авлигаас урьдчилан сэргийлэх нийт 12 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 73 албан хаагч хамрагдсан байна. Үүнээс 4 удаагийн сургалтад ЭБАТ хамрагдсан. | 100% |
| 3. | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах | -Байгуулсан гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх<br>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх | Жилдээ | Тухай бүрт | - | Албан хаагчдын Албан тушаалын тодорхойлтод авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан. | 70% |
| 4 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 4.1.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах | Арга хэмжээ зохион байгуулсан байх | Жилдээ | Тухай бүрт | | -"Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг", "Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийг Авлигатай тэмцэх газраар хянуулж, хууль журамд нийцүүлэн томилгоо хийн ажиллаж байна. Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд удирдах албан тушаалын 1, гүйцэтгэх албан тушаалын 1 нийт 2 сул орон тоог нөхөх захиалгыг Төрийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж, удирдах албан тушаалын 1, гүйцэтгэх албан тушаалын 1 орон тоон дээр сонгон шалгаруулалт явуулж хуулийн дагуу томилогоог хийлээ. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт, 44 дүгээр зүйлийн 44.5 дэх хэсгийн дагуу 3 албан хаагчийг дэвшүүлэн томилсон. Хуулийн дагуу 2 албан хаагчийн ХАСХОМ-ийн өөрчлөлтийг шинэчлэн бүртгэлээ. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны 2 гишүүнээс “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргуулан цахим бүртгэлийг хийсэн.<br><br>-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээлэл, байгууллагын зорилго зорилт, үндсэн чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, албан хаагчдын мэдээлэл, төрийн үйлчилгээ болон хүний нөөц, санхүүгийн ил тод байдал, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тогтмол шинэчлэн ажилласан.<br><br>-Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлын хүрээнд олон нийтийн цахим хуудсаар 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар нийт 644 мэдээ мэдээлэл түгээж, хандалтын тоо 1,067,152 хүрсэн байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Тухайлбал:<br>➢ www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 231 мэдээ, мэдээлэл оруулж, хандалтын тоо 88,000<br>➢ www.visitulaanbaatar.net цахим хуудсанд 68 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж хандалтын тоо 32,510<br>➢ https://www.facebook.com/UlaanbaatarTourism цахим хуудсанд 194 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 31,755, хандалтын тоо 832,144<br>➢ https://www.instagram.com/visit.ulaanbaatar/ цахим хуудсанд 117 фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 320, хандалтын тоо 55,274<br>➢ https://www.youtube.com/channel/UCjnuixwnzpDZzieEnhXfPFA цахим хуудсанд 34 дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 397, хандалтын тоо 27,449 байна.<br><br>-Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”-ыг хүрээнд нийслэлийн https://www.ulaanbaatar.mn/ портал системийн “Онлайн бизнес төв”-ийн “Үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл” цэсэд 310 иргэн, хуулийн этгээд зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйлчилгээ эрхлэхээр бүртгүүлж хүсэлтийг тухай бүр хянан шийдвэрлэсэн.<br><br>-Жуулчны мэдээлэл сурталчилгааны | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төвөөр 3700 гаруй иргэд жуулчдад шаардлагатай мэдээлэл, тараах материалаар ханган ажилласан бөгөөд лавлах утсаар дамжуулан 700 гаруй иргэд жуулчдад мэдээлэл өгч ажилласан.<br>-2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар нийт 16 өргөдөл, гомдол ирсэнийг хугацаанд нь 100 хувь шийдвэрлэсэн 15, судлагдаж байгаа 1 өргөдөл, гомдол байна. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 05 хоног 19 цаг 35 минут байна.<br>-Байгууллагын даргаас гарсан хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой Б/46 тушаалыг гаргаж, төсөв санхүү, арга хэмжээтэй холбоотой А/40 тушаалыг сайт болон шилэн данс, ublegal.mn сайтад нээлттэй байршуулан ажилласан. | |
| 5 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 5.1.Удирдлагын зүгээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах | Танилцуулга арга хэмжээг зохион байгуулсан байх | Жилдээ | Тухай бүрт | - | Нийслэлийн Аялал жуулчлалын газрын "Авлигын эсрэг үйл ажиллагаа"-ны 2024 оны төлөвлөгөөг 2024 оны 03-р сарын 18-ны өдөр газрын даргаар батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг газрын даргын хурлаар танилцуулан ажиллаж байна. | 100% |
| | | 5.2.Худалдан авах ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах. (Үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулах, тогтмол оруулахаас зайлсхийх зэрэг | Ажил, арга хэмжээ зохион байгуулсан байх | Жилдээ | Тухай бүрт | | Худалдан авах ажиллагааны хөтөч сургалтын төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, нийт 18 албан хаагчийг хамруулж, 5 албан хаагч гэрчилгээтэй болоод байна. Нийслэлийн Худалдан | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн ажил зохион байгуулах) | | | | | авах ажиллагааны газраас зохион байгуулсан 3 удаагийн сургалтад 4 албан хаагч хамрагдсан. | |
| | | 5.3.Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулах (2022 оноос хэрэгжиж эхэлсэн Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах, мөн жил бүр Үндэсний Аудитын газар болон Нийслэл дэх Төрийн Аудитын газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын шалгалтаар жил бүр илэрдэг санхүүгийн зөрчил, дутагдлыг цаашид гаргахгүй байхад чиглэсэн үр дүнтэй ажил зохион байгуулах) | Ажил, арга хэмжээ зохион байгуулсан байх | Жилдээ | Тухай бүрт | - | -Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагаанд 2024 онд Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөнд байгууллагын төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах чиглэлээр тусгаж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж байгаа бөгөөд сар бүр мэдээг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.<br>2024 оны байгууллагын санхүү, үйл ажиллагаанд төрийн болон Нийслэлийн дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдэж, шалгалтын мөрөөр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын 2024 оны төсөвт бичиг хэргийн зардалд 1,466,000 төгрөг, тээвэр шатахууны зардалд 16,896,000 төгрөг, шуудан холбоо, интернэтийн төлбөрт 5,160,000 төгрөг нийт 23,522,000 батлагдаж 2024 оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар бичиг хэргийн зардалд 1,001,460 төгрөг, тээвэр шатахууны зардалд 6,273,500 төгрөг, шуудан холбоо, интернэтийн төлбөрт 1,963,465.02 төгрөг нийт 9,238,425.02 төгрөг зарцуулж санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж санхүүгийн тайлан мэдээг тухай бүр хугацаанд нь | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тайлагнаж, шинээр авлага, өр төлбөр үүсгээгүй, он дамжсан, насжилт өндөртэй өр, авлага үүсгээгүй. Газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүрэг, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд байгууллагын нэмэлт дансанд нийслэлийн төсвөөр санхүүжиж эвент арга хэмжээ зохион байгуулахад 959,532.4 төгрөг, сургалт зохион байгуулахад 264,160.0 төгрөг, маркетинг, сурталчилгаа, хамтын ажиллагааны чиглэлээр 695,372.4 төгрөгийг батлуулж гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн баримтын бүрдлийг тухай бүр хангуулан тайлагнан ажиллав. | |
| | Хэрэгжилт | | | | | | | 97% |

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА Д.БАТСҮХ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ, ЁС ЗҮЙ ДОТООД
АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Ш.УНДАРМАА

Цахим хуудсуудаар дамжуулан хийсэн ажил.




























# АВЛИГАД ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЦГЭЭЕ
АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА НЬ
АВЛИГА БИШ
110 АВЛИГЫГ МЭДЭЭЛЭХ УТАС




# АВЛИГАД ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЦГЭЭЕ
ЭРҮҮЛ НИЙГМИЙГ ЦОГЦЛООХОД ТАНЫ ОРОЛЦОО ХЭРЭГТЭЙ
110 АВЛИГЫГ МЭДЭЭЛЭХ УТАС




Мэдээллийн төвүүдээр дамжуулан сурталчилгааны материал тарааж, байршуулсан.













Албан хаагч нарт мэдээлэл хүргэж, иргэдэд тараасан материал.







